



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1998 оны 02 дугаар сарын 06 өдөр

Дугаар А-15

Улаанбаатар хот

Мал эмнэлэг, үржлийн алба,
салбарыг татан буулгах тухай

1. Монгол улсын Засгийн газрын 1997 оны 167 дугаар тогтоолыг үндэслэн дүүрэг, хороодын Мал эмнэлэг үржлийн албадыг 1998 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс дуусгавар болгон татан буулгасугай.

2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, 167 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, дүүрэг хороодын Мал эмнэлэг үржлийн албадыг аж ахуйн тооцооны зарчмаар Улсын үйлдвэрийн газар болгон ажиллуулахыг дүүргийн Засаг дарга нар, тосгоны захирагч нарт зөвшөөрсүгэй.

3. Энэ захирамж гарсантай холбогдон Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1991 оны 137 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 1994 оны А/29 дүгээр захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ж.Наранцацралт Ж.НАРАНЦАЦРАЛТ